



СЭЛЭНГЭ АЙМАГ  
ОРХОНТУУЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 01

Баянцогт

Сумын ГХУСАЗСЗ-ийн 2017 оны ажлын  
төлөвлөгөө батлах тухай

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2017 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн талаарх тус зөвлөлийн нарийн бичгийн дарга, Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Б.Батсаруулын илтгэлийг хэлэлцээд,

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2017 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.


2. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөсөн хугацаанд шуурхай зохион байгуулж, хэрэгжилт үр дүнд хүрэн ажиллахыг тус зөвлөлийн нарийн бичгийн дарга, Хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн дэслэгч Б.Батсаруулд үүрэг болгосугай.

ДАРГА



М.ЦОГБАЯР

Орхонтуул сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2017.01.27-ны өдрийн 01 тоот тогтоолын хавсралт



**ОРХОНТУУЛ СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
<i>Нэг. Зохион байгуулалтын ажлын чиглэлээр</i>				
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2017 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулан ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах	1-р сард	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга	ГХУС ажлыг жилийн турш төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажилласнаар гэмт хэрэг буурна.
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2017 оны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжинд нийцүүлэн төлөвлөж батлуулах	2-р сард	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга	Төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлснээр төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэх хөрөнгө санхүүгийн боломжтой болно.
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлыг улиралд нэг удаа хийж өмнөх улиралд хийсэн ажлаа дүгнэж дараа улиралд хийх ажлаа танилцуулах.	Улирал тутам	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга, дарга	Зөвлөлийн ажил сайжирч, төлөвлөсөн ажлууд хугацаандаа чанар, үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
4	Сумын хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээг сар бүр гаргаж шалтгаан нөхцлийг судлан холбогдох арга хэмжээ авч ажиллах.	Сар бүр	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга	Гэмт хэргийн гаралт шалтгаан нөхцлийг илрүүлснээр түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад хялбар болно.
<i>Хоёр. Нийтийн хэв журам сахиулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын чиглэлээр</i>				
1	Сумын ИТХ-ын 2013 оны 35 тоот "Төрийн оролцоотой аливаа арга хэмжээнд архи, согтууруулах ундаа хэрэглэх, түүгээр үйлчлэхийг хориглох	2-р сард	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга, ТЗХЭССХ Мэргэжилтэн	Энэхүү тогтоол, хөтөлбөрийн биелэлт хангагдсанаар иргэдийн архи согтууруулах ундааны хэрэглээ багасч үүнтэй уялдан

	тухай” тогтоол болон 2014 оны 38 тоот тогтоолоор баталсан “Архигүй Орхонтуулчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллах		Д.Мэнд-Амар	Гэмт хэргийн гаралт буурч иргэдийн амар тайван амьдрах нөхцөл бүрдэнэ.
2	Амралт, баяр ёслолын өдрүүдэд нэгдсэн болон хэсэгчилсэн, хамтарсан арга хэмжээнүүдийг зохион явуулж баримтжуулах	Тухай бүр	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга	Иргэд аюулгүй тайван нөхцөлд амарч, баяр ёслолоо тэмдэглэн өнгөрүүлнэ.
3	Тус сумын хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгүүдэд үзлэг шалгалтыг хийж зөрчил дутагдалыг арилгах	Тухай бүр	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга, ТЗХЭССХ Мэргэжилтэн Д.Мэнд-Амар	Зөрчил дутагдлыг арилгаснаар стандартын дагуу үйлчилгээ явагдана.
4	Архины хамааралтай хүмүүс архаг архичдыг албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулах.	Жилд	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга, ЭМТөвүүд	Эдгээр хүмүүсийг архинаас хамааралгүй болгосноор зөв амьдрах зорилготой иргэдийн тоо нэмэгдэнэ.
5	Гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг этгээдүүдийн судалгааг үндэслэн урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах буюу сургалт мэдээллийн ажил зохион байгуулна.	Жилд	Сумын болон сургуулиудын Нийгмийн ажилтнууд	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн тоо буурна.
6	Нийтийн хэв журам хамгаалах эргүүлийн үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулж ажиллуулах.	Жилд	Сумын болон сургуулиудын Нийгмийн ажилтнууд	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо сайжирна.
7	Эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодож буй иргэд болон хүүхдүүд ялангуяа мотоциклийг эрхийн үнэмлэхгүй жолоодох явдлыг таслан зогсоож, үнэмлэхжүүлэх талаар ажил зохион байгуулах.	Жилд	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга	Авто тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлнэ.

**Гурав. Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр**

1	Хулгайлах болон бусад төрлийн гэмт хэргийн талаарх мэдээллийг төлбөртэй авах, нууцлалыг хадгалах талаар арга хэмжээ авах.	Жилд	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга, Багийн Засаг дарга нар	Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлж, мэдээллийн нууцлалыг хадгалснаар мэдээлэл өгөх иргэдийн тоо ихэснэ.
2	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх	Сар бүр	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн	Мал хулгайлах гэмт хэргийн гаралт

	ажлын хүрээнд Малчдын бүлгэмүүдтэй хамтарч ажиллана.		дарга Багийн Засаг дарга нар	буурна.
3	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх санг бүрдүүлэн дүрмийн дагуу зарцуулж, малын хулгайн гаралтыг бууруулах	Жилд	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сангийн зөвлөл  Багийн Засаг дарга нар	Малчдын малын хулгайн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэхэд оруулах хувь нэмэр, үүрэг оролцоо дээшилнэ.
<b>Дөрөв. Сургалт сурталчилгааны ажлын чиглэлээр:</b>				
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалтыг ААН, байгууллагууд болон багийн Иргэдийн Нийтийн Хурлуудад танилцуулж, гарын авлага материалаар хангаж ажиллах	Улирал тутам	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга, Зөвлөлийн гишүүн Д.Мэнд-Амар	Гэмт хэргээс сэргийлэх тухай хуулийг иргэд олон нийтэд таниулснаар иргэдийн хуулийн мэдлэг мэдээлэл сайжирна.
2	Гэмт хэрэгт өртөж болзошгүй хүүхдүүдийн судалгааны дагуу сургалт мэдээллийн олон талт арга хэмжээ зохион байгуулах	Улирал тутам	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга, ТЗХЭССХ Мэргэжилтэн Д.Мэнд-Амар, НА Б.Хосцэцэг, Н.Буянтөгөлдөр, Б.Дэлгэрнаран	Насанд хүрээгүй хүүхдүүд гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэлтэй болж, энэ ажилд сургууль, эцэг эхийн хамтын ажиллагаа сайжирна.
3	Сургуулийн сурагчдад ГХУС тухай хуулийн сургалт хийн урлаг, спорт, танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулах	3, 10-р саруудад	ГХУСАЗСЗ-н нарийн бичгийн дарга, ТЗХЭССХ Мэргэжилтэн Д.Мэнд-Амар, НА Б.Хосцэцэг, Н.Буянтөгөлдөр, Б.Дэлгэрнаран	Урлаг, спорт, танин мэдэхүйн арга хэмжээгээр дамжуулан насанд хүрээгүйчүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үзэл төлөвшил бүрдэнэ.